



МОНГОЛБАНК
САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

МОНГОЛБАНКНЫ ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БҮТЭЭЛИЙН УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

**(Санхүүгийн мэдээллийн албаны дэргэдэх Хамтын ажиллагааны зөвлөлийн Судалгаа
дүн шинжилгээний ажлын хэсгийн хүрээнд)**

НЭГ. ЗОРИЛГО

Судлаачдыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл туурвихад уриалж сэдэлжүүлэх, бүтээлийг нь олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлогын шийдвэр гаргалтад оролцох оролцоог нэмэгдүүлэхэд энэхүү эрдэм шинжилгээний бүтээлийн уралдааны зорилго оршино.

ХОЁР. СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1 Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах;
- 2.2 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо эдийн засаг, санхүүгийн салбарт үзүүлэх нөлөө;
- 2.3 Санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдэд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх нөлөөлөл;
- 2.4 ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орон буюу саарал жагсаалтад орсны эдийн засагт үзүүлэх нөлөөлөл;
- 2.5 ФАТФ-ын 40 Зөвлөмжийг Монгол Улсад хэрэгжүүлэх үр дүнтэй арга аргачлал;
- 2.6 КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл;
- 2.7 Санхүүгийн болон санхүүгийн бус бизнес, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчдийн комплаенсийн тогтолцоог сайжруулах;
- 2.8 Корреспондент банкны харилцааг сэргээх;
- 2.9 Цахим гэмт хэрэг, луйвар, залиланг бууруулах оновчтой арга аргачлал;
- 2.10 Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэл;
- 2.11 Монгол Улс дахь виртуал хөрөнгө, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн

мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зохицуулалт;

2.12 Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх индексийг тооцох;

2.13 Зэрлэг ан амьтдыг хууль бусаар худалдаалах замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэг үйлдэх явдал;

2.14 Байгаль орчны гэмт хэргээс мөнгө угаах явдал;

2.15 Гадаад худалдаанд суурилсан мөнгө угаах явдал;

2.16 Хуулийн этгээдээр дамжуулан мөнгө угаах явдал;

2.17 Хөдөө орон нутагт байршилтай мэдээлэх үүрэгтэй этгээдийн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо, эрсдэл, эмзэг байдал;

2.18 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гарч буй дижитал шилжилт;

2.19 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбоотой бусад сэдвүүд болно.

ГУРАВ. БҮТЭЭЛД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

3.1 Бүтээлийн агуулгын хувьд:

- Онол, арга зүйн үндэслэлтэй;
- Шинэлэг, оновчтой санал, санаачлага дэвшүүлсэн;
- Бодит мэдээлэл ашиглаж, баримтаар баталгаажуулсан;
- Бодит байдалд хэрэгжиж болохуйц;
- Бусдын ажлыг шууд хуулбарлаагүй;
- Судалгаанд ашигласан материалыг бүрэн дурдсан;
- Орчин үеийн шинэ арга, хэрэгслийг ашигласан байх;
- Асуудал дэвшүүлж, тодорхой шийдэл, дүгнэлт, зөвлөмжийн шийдэл гаргасан байх.

3.2 Оролцогчдын хувьд:

- Багаар оролцож болох бөгөөд гишүүдийн тоо 3-аас ихгүй байна;

3.3 Бичгийн стандарт:

- Үсгийн фонт - Times New Roman /”Mon” өргөтгөлтэй фонт байж болохгүй/;
- Фонтын хэмжээ - 12;
- Мөр хоорондын зай - 1.5;
- Хуудас: дээд захаас 20 мм, доод захаас 20 мм, зүүн захаас 30 мм, баруун захаас 15 мм;
- Цаасны хэмжээ: А4

- Судалгааны хураангуй хэсгийг бичсэн байх;
- Нүүр хуудсанд нэр, холбоо барих 2 утасны дугаар, и-мэйл хаяг, ажлын болон сургуулийн нэр, курс, мэргэжил, судалгааны ажлын нэрийг бичих;
- Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх;
- Илтгэл нь гарчиг, хураангуй, удиртгал, судалгааны хэсэг, дүгнэлт ном зүй гэсэн үндсэн хэсгүүдийг багтаасан байх;
- Оюуны бүтээлийг зөвшөөрөлгүй хуулбарлаагүй байх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах).

ДӨРӨВ. УРАЛДААНЫ ҮЕ ШАТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

4.1 Нэгдүгээр шат: Зохион байгуулах комисс бүтээлийг цахим хэлбэрээр хүлээн авч судалгааны ажлыг дүгнэх.

4.2 Хоёрдугаар шат: Санхүүгийн мэдээллийн алба болон шүүгч нараас бүрдсэн баг шүүж нэгдсэн дүнг гаргана.

4.3 Эцсийн шатанд шалгарсан бүтээлүүдийн хэлэлцүүлэгт тавигдах шаардлага:

- Илтгэлийн PowerPoint файлыг ирүүлэх;
- Илтгэл нь гарчиг, удиртгал, үндсэн хэсэг, дүгнэлт, ном зүй гэсэн хэсгүүдээс бүрдсэн байх;
- Санаагаа ойлгомжтой, цэгцтэй хүргэх;
- Асуултад оновчтой хариулах;
- Илтгэлийн хугацаа: 10 минут.

ТАВ. ШАГНАЛЫН САН

5.1 Судлаачийн ангилал

- 1-р байр - Өргөмжлөл, 2 500 000 /Хоёр сая таван зуун мянган төгрөг/;
- 2-р байр - Өргөмжлөл, 2 000 000 /Хоёр сая төгрөг/;
- 3-р байр - Өргөмжлөл, 1 500 000 /Нэг сая таван зуун мянган төгрөг/.

ЗУРГАА. МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ

Хугацаа: 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 17:00 цаг хүртэл бүтээлийн хэвлэмэл 2 хувийг Монголбанкны бичиг хэрэгт болон цахим хэлбэрээр fiu@mongolbank.mn хаягаар хүлээн авна.

**Бага тойруу 3, 15160, Улаанбаатар, Монголбанкны “Д” байр
Санхүүгийн мэдээллийн алба
МОНГОЛБАНК**

Дэлгэрэнгүй мэдээллийг fiu.mongolbank.mn веб хуудаснаас болон (976) 11-326161 утсаар лавлана уу.